-Цахилгааны өрөөнд нэмэлтээр гал унтраах автомат төхөөрөмж /Тунгус-6/ 2ш-ийг тоноглох

- Кабелийн вирк схем, галын аюулгүй ажиллагааны плакат хийх шаардлагатай

Цахилгааны дэд өртөө 37-1, 37-2

- Трансформаторын тос солих

-SEL-751 реле хамгаалалтын төхөөрөмж тавих

- Резинэн шал хийх

- Гадна гэрэлтүүлэг, саравч кабелийн холболтын ажлыг гүйцээх

-Спринклерийн автоматжуулалтын холболтыг гүйцээх

- Схем вирк монгол хэл дээр хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Очиртааб ХХК-ны Цахилгааны инженер Б.Гантуяа

Заставын барилга:

- Нэгдүгээр давхарт бууж байгаа бохирын шугамын ард орсон унтраалгын хаалга руу зөөх, ЕС-аас гарч байгаа кабелиудад хаяг өгөх, цахилгаан самбаруудад схем хийж өгөх.

Халдваргүйтгэлийн барилга:

- Ариутгах төхөөрөмжийг ирэхээр цахилгааныг холбох, цахилгааны самбаруудад схем хийж өгөх, кабелиудад монголоор хаяг (вирк) хийж өгөх, бүх барилга дээр цахилгааны самбаруудад схем хийж өгөх, кабелиудад монголоор хаяг (вирк) хийж өгөх.

Нэг цэгийн шалган нэвтрүүлэх:

- Зураг төслийн дагуу хийсэн байна. Самбарт схем хийх, ЕС-аас гарч байгаа кабелиудад хаяг (вирк) хийж өгөх.

Хилийн хяналтын байгууллагуудын шалгалтын барилга:

- Зураг төслийн дагуу хийгдсэн. Цахилгаан самбаруудад схем хийх, Кабелиудад хаяг монголоор хийх.

Эрэлч нохойн өвлийн сургалт:

- Зураг төслийн дагуу дууссан.

Авто пүүний удирдлагын барилга:

- Зураг төслийн дагуу хийгдсэн.

Шалгагчийн кабин:

- Кабины дотор цахилгааныг зургийн дагуу хийж дуусгах.

Мэргэжлийн хяналт гаалийн газрын агуулах:

- Гаалийн ажилтны өрөөнд зургийн дагуу розетка гаргаж өгөх.

Гаалийн газрын агуулах:

- Зураг төслийн дагуу хийгдсэн байна.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга Ц.Баярмаа:

- Гадна цахилгаан хангамж, дэд өртөөний гүйцэтгэлийн зургийг гаргаж Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастрын цахим мэдээллийн санд бүртгүүлэх

-Улсын болон техникийн комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах төлөвлөгөө гаргаж захиалагч, захиалагчийн хяналт гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаажуулж, албан бичгээр Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ирүүлэх

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гадна цахилгаан хангамж, дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийн ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Ажлын хэсэг №3 Ус дулаан дамжуулах төв, Бохир усны насос станц, гадна инженерийн шугам сүлжээ, дотор сантехник, салхивчийн ажил:

Комиссын дарга Ц.Баярмаа:

Ус дулаан дамжуулах төв, Бохир усны насос станц, гадна инженерийн шугам сүлжээ, дотор сантехник, салхивчийн системийн ажлын хэсэг Зорчигч тээврийн хэсгийн барилга байгууламжийн гадна дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэл болон холбогдох бичиг баримттай танилцаж дууссан байна. Гишүүд үүрэг даалгавар, санал дүгнэлтээ танилцуулна уу.

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөл хэрэгжүүлэх нэгжийн дулааны инженер Ц.Жаргалсайхан:

- №35-д суурилуулсан бүх тоног төхөөрөмжийн зарчмын схем зураг хийж байрлуулах
- №35 удирдлагын шкафт гарч буй хятад тайлбарыг Монгол хэлрүү орчуулах
- №35 шугам хоолойг дулаалах
- №35 тоолуурууд суурилуулах
- Дулааны шугамын төгсгөлд нэмэлт насос нэмж суурилуулах
- Нэн яаралтай цэвэр усны шугам хоолойг ажиллагаанд бэлдэх
- Дутуу ажлаа хийж гүйцэтгэх тодорхой хугацаатай график хийж батлуулах
- Цахилгаан соронзон ус зөөлрүүлэгч ионжуулагч төхөөрөмж нэмж суурилуулах
- №38-1, №38-2 өргөх насосны орох хоолойд сараалж хийх
- №38-1, №38-2 насос өргөх тросс хийх
- Ус халаах бойлуурын хүчин чадлыг нэмэх

Дээрх дутуу ажлыг хийж гүйцээгээд хүлээлгэж өгсөн тохиолдолд үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авахад татгалзах зүйлгүй.

“Очиртааб” ХХК-ийн Дулааны инженер М.Мархамет:

- Гадна шугам сүлжээний ажлыг ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Дулааны болон цэвэр усны шугамыг угсармал төмөр бетон сувагт төлвөлсөн байдлыг цутгамал төмөр бетон худаг ба сувагт угсарсан байна. Зургийн өөрчлөлтийн гүйцэтгэлийн зураг хийж зураг зохиогчтой зөвшилцсөн байна. Халаалтыг хувийн зуухаар хангах зураг анх хийгдсэн ба дулааны станцтай хангагч байгууллагатай зөвшөөрөлцөж дулааны 5 шугамнаас хангаж байгаа болно.

- Төгсгөлийн барилгуудын халаалт жигд биш байгаа тул дулаан хуваарилах төвд тохируулга хийх ба халахгүй байгаа барилгуудын халаалтын системд эргэлтийн насос төлөвлөж өгөх шаардлагатай байна.

- Дулаан хуваарилах төв барилгын хэрэгцээний халуун усны системийн ялтсан ус халаагчийн хүчин чадлыг тодруулах. Техникийн паспортыг үзэх шаардлагатай. Хэрэглээний халуун усны ус халаагчийн хүчин чадал ажлын зурагт зааснаас бага байна.

- Техникийн комисс ажиллах үед тавигдсан шаардлагууд хийгдээгүй дутуу байгааг гүйцээх.

- Дулаан хуваарилах төв барилгын 2-р хэлхээнд зургийн дагуу дулааны хэмжих хэрэгсэл тавьж өгөх.

- Цэвэр усны шугаманд усны шугаманд ус тавигдаагүй байгаа учир цэвэр усыг тавьж ашиглалтанд хүлээж авах

- Ус дулаан дамжуулах төв барилгын дулааны зарчмын схем гаргаж бүх шугам хоолойг зохих өнгөөр ялгаж, тоног төхөөрөмжийн хаяг тодорхойлолтуудыг Монгол хэлээр бичиж хаягжуулах шаардлагатай.

- Халаалтыг өгөөгүй туслах барилгуудад халаалт тавих.

Дээрх дутуу ажлыг гүйцээж хийж, зарим барилгын халаалтын ажлыг жигдрүүлсний дараа улсын комисст хүлээн авах саналтай байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер Ө. Мөнх-Отгон:

- Ус цэвэршүүлэх төхөөрөмж зураг төсөлд байна. /хийлгэх/
 - Дулааны тоолуур тавих
 - Бүх тоног төхөөрөмжийн удирдлагын самбар тоноглолыг баталгаат орчуулгын газраар орчуулуулах
 - 17-р браилга дээр нэмэлт насос нэмж тавих
 - Халдваргүйтгэлийн барилгын төгсгөлд бохирын гадна шугамд халаагч кабель суурилуулах
 - 2022 оны 12 сарын 15-нд ажилласан техникийн комиссын биелэлтийг хангуулах
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

"Замын-Үүдийн Дулаан станц" ТӨҮГ-ын захирал О.Төмөрхуяг:

- Стандартчлал хэмжилзүйн газарт бүх хэмжүүрийг баталгаажуулах
- Халаалт муу байгаа 2 барилгад насосны узельтэй болгох
- Дулааны өгөх, буцах шугамыг ТА дүрэмд зааснаар дулаалах /түлэгдэх аюултай/
- Нэг болон хоёрдугаар контурын шугаман дээр зарцуулалтын хэмжүүр тавих, дулааны тоолуур шинээр угсарч монтажлах
- HYDRO-X буюу зэв арилгах төхөөрөмж тавьсан. Одоо 2-р контурт явж байгаа сүлжээний усны хатуулаг 5500мкг/дм^3 байгаа нь техник ашиглалтын дүрэмд заасан норм хэмжээнээс их байгааг хэвийн хэмжээнд болгох /Одоо 10 дахин их байна/
- Хэрэглээний халуун усны ялтсан бойлерын хүчин чадлыг багаар тооцож тавьсан байна. /нэмэх/
- Узель доторх хаягжуулалт байхгүй, шуурхай ажиллагааны үед онц шаардлагатай байдаг. Ялангуяа системд гэмтэл гарсан, ус алдсан тохиолдолд нэн шаардлагатай.
- Халаалт авч байгаа хэрэглэгчдийн сүлжээний схем мөн Ус дулаан дамжуулах хуваарилах төвийн технологийн схемийг гаргаж өгөх. Ус дулаан дамжуулах хуваарилах төвийн бүх тоноглолын ашиглалтын паспорт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг монгол хэл дээр болгож ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх
- Гагнуурын оёдолд металл судлалын шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах
- Шугам хоолойг таних тэмдэгээр ялгах
- Бүх тоног төхөөрөмжинд ашиглалтын заавар боловсруулах
- Шугам сүлжээний эзэмшлийн заагийн схемийг тогтоох
- Соруулах худгийг хөлдөлтийн гүнээс доош болгох
- Нэмэлт ялтас резерв тавьж өгөх

Дээрх асуудлуудыг шийдвэрлэсэн тохиолдолд улсын комисс авахад татгалзах зүйлгүй.

“Очиртааб” ХХК-ийн ус хангамж, ариутгах татуургын инженер П.Чулуунцэцэг:

Зорчигчийг шалган нэвтрүүлэх барилга:

- Улсын комисс ажиллах үед цэвэр усны шахалт хийгээгүй байсан тул цэвэр ус шахсаны дараа системийн туршилт тохируулгыг хийх

- Тоног төхөөрөмжийг ажиллуулах зааварчилгааг монгол хэлээр бичиж байрлуулах (Усан буу, хийн систем, спринклер).

Хил хамгаалах байгууллагуудын шалгалтын барилга:

- Техникийн комиссоор ажиллах үед өгсөн үүрэг даалгаврын дагуу сантехникийн тоноглолуудыг угсарч борооны усны хаялгыг зассан.

Нэг цэгийн шалган нэвтрүүлэх барилга:

- Ажлын зургийн дагуу хийгдсэн.

Халдваргүйтгэлийн барилга:

- Халдваргүйтгэлийн багана суурилуулах болон технологийн тоног төхөөрөмжүүдийн холболт хийх дутуу

Нохойн өвлийн сургалтын барилга:

- Ажлын зургийн дагуу хийгдсэн.

Гааль болон мэргэжлийн хяналтын засвар:

- Ажлын зургийн дагуу хийгдсэн.

Заставын барилга:

- Бохир усны босоо шугаманд хаалт хийх.
- 16 номерын ариун цэврийн өрөөнд хананд байгаа усы цоргыг угаалгын машиныг холболт болгох бохирын шугаманд угаалгын таг өгөх.

Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

“Очиртааб” ХХК-ийн халаалт, агаар сэлгэлтийн инженер У.Батдэлгэр, Саябум:

Зорчигч шалган нэвтрүүлэх барилга:

- Шалны халаалтын систем ажиллагаанд холбоогүй байна. Үндсэн халаалтын системийг ажиллагаанд оруулж байна.

- Үндсэн цахилгаан хангамж ирээгүй тул агаар сэлгэлтийн төхөөрөмжүүдийг ажиллагаанд оруулаагүй байна. Агаар сэлгэлтийн төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн ажиллагаанд оруулж туршилт торхируулгыг хийж хүлээлгэн өгөх шаардлагатай.

- Хөргөлтийн системийн ажлыг бүрэн хийж дуусгасан байна. Ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх ажлыг захиалагчтай тохирч хийх

- Гадна хаалганы агаарын цахилгаан хөшгийг чанартай сайн төхөөрөмжөөр солих шаардлагатай

Нэг цэгийн шалгалтын барилга:

- Тус барилгын халаалт, агаар сэлгэлт, хөргөлтийн системийг зураг төслийн дагуу хийсэн байна.

Хилийн заставын барилга:

- Тус барилгын халаалт, агаар сэлгэлт, хөргөлтийн системийг зураг төслийн дагуу хийсэн байна.

- Системийг ажиллагаанд оруулаагүй байгаа тул ашиглалтад оруулж захиалагч талд хүлээлгэн өгөх шаардлагатай

Агуулахын барилга:

- Тус барилгын халаалт, агаар сэлгэлт, хөргөлтийн системийг зураг төслийн дагуу хийсэн байна.

- Сорох системийн сараалжийг угсрах шаардлагатай.

Бүх барилгуудын халаалт, агаар сэлгэлт, хөргөлтийн системүүдийг шалган баталгаажуулж ашиглалтад авахад бэлэн болсон үед улсын комист авах саналтай байна.

Комиссын дарга Ц.Баярмаа:

- Гадна инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн зургийг гаргаж Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастрын цахим мэдээллийн санд бүртгүүлэх

-Зорчигчийг шалган нэвтрүүлэх барилгын шалны халаалтыг өгөх

-Зарим барилгуудад халаалтыг бүрэн өгч жигдрүүлэх

- Хэрэгцээний халуун усны бойлерын хүчин чадлыг нэмэгдүүлэх

-Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах төлөвлөгөө гаргаж захиалагч, захиалагчийн хяналт гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаажуулж, албан бичгээр Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ирүүлэх

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ус дулаан дамжуулах төв, Бохир усны насос станц, гадна инженерийн шугам сүлжээ, дотор сантехник, салхивчийн ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Ажлын хэсэг №4 Гадна холбоожилт, дотоод сүлжээ, гал унтраах систем:

Ажлын хэсэг №5 Барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, үндсэн хийц бүтээц:

Комиссын дарга Ц.Баярмаа:

Зорчигч тээврийн хэсэгт шинээр баригдсан болон их засвар хийгдсэн бүх барилга барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, үндсэн хийц бүтээц, гадна холбоожилт, дотоод сүлжээ, гал унтраах системийг шалгасан ажлын хэсгийн гишүүд барилга байгууламжийн гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж, холбогдох бичиг баримттай танилцаж дууссан байна. Гишүүд үүрэг даалгавар, санал дүгнэлтээ танилцуулна уу.

Ажлын хэсэг №4

“Очиртааб” ХХК-ийн холбооны инженер Т.Пүрэвзагд:

Зорчигчийн шалган нэвтрүүлэх цогцолбор:

- Утасны кабелиудыг хаягжуулах

- Нэгдсэн системүүдийг ажиллагаанд бүрэн оруулах

- Дутуу ажлуудыг гүйцээх

Бусад барилгууд:

- Дутуу ажлуудыг гүйцээж нэгдсэн системд холбох

Гадна холбоо:

- Худагт (өндөр хүзүү хийсэн) шат хийх (засвар үйлчилгээ хийх) боломжийг хангах

- Утас кабелиудыг цэгцлэх, хаягжуулах

Агуулах, застав, ариутгалын барилга:

- Оролтын хоолойг дахин өөр кабелиуд сүвлэх боломжийг гаргаж цэгцлэх хэрэгтэй.

- Барилгуудын гадна холбооны кабелиудыг монголоор хаягжуулах

- Гадна шилэн кабель (галын дохиолол, ажиглалтын системийн) болон физик кабель тархалт өөрчилсөн хэсэгт гүйцэтгэлийн зураг гаргах.

- Бүх барилгуудад суурилуулсан галын дохиолол, ашиглалт хяналт, зарлан мэдээлэх системийн тоног төхөөрөмж дээр ажиллах зааварчилгааг ашиглагч байгууллагуудад өгөх, мөн монгол англи хэлээр гарын авлага бэлдэж өгөх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн холбоо дохиоллын инженер Г.Чинзориг:

Гадна холбоо:

- Худаг, сувагчлалын трассыг мэдээллийн системд бүртгэх ажилд бэлдэх
- Худгийн тоноглол дутуу ажлыг гүйцээх
- Худаг доторх шилэн болон физик, галын дохиоллын кабелиудыг цэгцтэй байрлуулах
- №1 барилгын 2-р давхраас “Замын-Үүд” сумын МХС ХХК-ийн серверлүү татах шилэн болон физик кабелийн ажлыг гүйцээж, хэмжилтийн протокол үйлдэх
- Худагт муфт, кабелийг хаягжуулах

Дотор холбоо:

- Серверийн болон раканд байгаа кабель, FDF, SWITCH, NVR зэрэг төхөөрөмжүүдийг биржжүүлэх
- №1 барилгын 2-р давхрын серверийн ерөөнөөс барилга, гэрэлтүүлгийн цамхагуудруу татсан шилэн кабелиудын хэмжилтийн протокол үйлдэж ашиглагч байгууллагад хүлээлгэж өгөх
- Галын дохиолол хяналтын системийн ажиллагааны гарын авлага ашиглагч байгууллагад гаргаж өгөх

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер Ц.Хэрлэн:

- Тоног төхөөрөмжүүдийн гарын авлага гаргаж өгөх
 - Цахилгаан, холбоо дохиоллын төхөөрөмжүүдийн кабелийг хаягжуулалтыг Монгол хэлээр орчуулж бирклэх
 - Зорчигчийн кабины сүлжээний кабелийг кабиныг зөөж датанд оруулах
 - Дотоод сүлжээг холбох нөхцөлийг бүрдүүлэх /700м кабель гүйцээж татах/
 - Худгуудад шат хийх. Зарим замбраагүй татсан кабелийг цэгцлэх
 - 2-р давхрын шилэн хаалтыг түр орлуулах материалаар хийж аюулгүй байдлыг хангах
 - Босоо шугамуудад хаалт хийх
 - Тоног төхөөрөмжүүдийн сертификатыг ашиглагчид хүлээлгэн өгөх
 - Гүйцэтгэлийн зураг гарган баталгаажуулж архивын материалд хавсаргах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер Н.Насанбаяр

- Барилга хоорондын холболтыг лазер хэмжилт хийх, акт үйлдэж зохиогчоор баталгаажуулах
 - Галын дохиоллын ерөнхий самбарын мэдээллэх хуудасын хэлийг солих
 - Галын дохиолол, интернэтийн сүлжээ, дотуур холбоо, холбооны ажлуудын тохиргоог хийх, холболтыг тестлэх
 - Гүйцэтгэлийн зураг гаргуулж зохиогчоор баталгаажуулах
 - Холбооны ерөөний ракуудыг газардуулгад холбох
 - Тоног төхөөрөмжийн сертификат, тохирлын гэрчилгээ, стандарт хангасан эсэхийг тодорхойлсон техникийн бичиг баримт бүрдүүлэх
 - Гадна холбооны ажлыг дулааны улиралд хийж дуусгах
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналтай байна.

“Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК-ийн Дорноговь аймаг дахь салбарын кабель шугамын инженер Ч.Түвшинжаргал, Т.Эрдэнэжаргал:

Барилга байгууламжийн гадна холбоо:

-№1-р барилгын оруулгын шахтан дахь кабелийг кронштейн хийж стандартын дагуу татах

-№1-р барилгын гадна оруулгын худагт хийгдсэн муфтнуудыг худагт ажиллахад саад болохооргүйгээр кронштейн дээгүүр татаж байрлуулах. Мөн худагт хийгдсэн хуваарилах хайрцгийг шилжүүлэх

-Бусад барилгын гадна холбоожуулалтын оруулга хэсгийг шавардаж битүүлсэн, уян хоолойгоор эргэлттэй хийгдсэн зэргээс шалтгаалж дахин кабель татах боломжгүйг анхаарч кабель татах боломжийг бүрдүүлэх /камерийн кабелийн хэсэг хамрагдана/

-Холбоожуулалтын техникийн нөхцөлийн дагуу тусгагдсан шилэн болон физик кабелийг бүрэн татаж холболтыг үүсгэн сүлжээг бүрэн оруулах

- Бүх худагт цэвэрлэгээ хийх, кабелийг стандартын дагуу кронштейн дээгүүр татаж, хаягжуулалт Монголоор хийх, хүзүүвч өндөрлөсөн болон 1,5м-ээс өндөр худагт шат хийх, таг хүзүүвчний бэхэлгээг дахин хийх

- Кабель татаж байх үед МХС-ний худгуудийн кабель цэгцгүй болгосоныг цэгцэлж худаг цэвэрлэх, гэмтээсэн таг, хүзүүвчийг засварлах

- Төмөр замын дагуу кабель шилжүүлэхэд зориулж хийгдсэн 5 худаг бүхий 700 гаруй сувагчлалын 2 худгийг зам талбайн шороо болон барилгын хогоор дарсан байгааг цэвэрлэж ил гаргах

- Дотор кабель, сүлжээнд Монголоор хаягжуулалт хийх. Рак болгонд тархалтын схемийн зургийг гаргаж байршуулах

- Худаг сувагчлал дагуух трассыг дахин булж, трассыг сэргээх /хилийн хашаанд/

- Барилга хооронд татагдсан /худаг, сувагчлалаар/ кабелийн тархалт дахилтын схем зураг гаргаж өгөх

- Худаг хоорондын янданг шалгаж баталгаа гаргаж өгөх МХС-д

Онцгой байдлын ерөнхий газрын Стандарт, норм, нормативын хяналт хариуцсан мэргэжилтэн, Дэд хурандаа Ч.Артаг:

- Олон улсын зорчигч, ачаа тээврийн цогцолбор барилга. Халдваргүйтгэлийн барилга болон зарим өрөөний галын дохиоллын мэдээлэгчийн байрлалыг засаж хийх

- Барилга бүрт байрлуулсан галын дотор усны даралтад цэгийн кран, холбох цоргыг нэг бүрчлэн ус тавьж шалган усны даралт, хүчин чадал тооцоог үзүүлэх

- Гал унтраах /усаар ханган/ гадна гидрантыг норм дүрэмд заасны дагуу төлөвлөн таганд тэмдэглэгээ хийх

- Барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн хүчин чадлыг тооцож нормын дагуу байрлуулах /MNS5566:2020/ стандартын дагуу байрлуулах

- Галын дохиоллын хүлээн авагч станцыг бүрэн шалгаж ашиглалтад оруулах /өрөө тасалгаа/

- Хилийн шалган нэвтрүүлэх барилгын доторх хаалгыг гарах чиглэлийн дагуу онгойдогоор төлөвлөж засах /БНБД-ийн 21-01-02/ дагуу

- Барилга бүрт бүрэн усан хамгамжийг оруулан спринклер системийн шугам хоолойг шалгах

- Эдгээр өгсөн үүрэг даалгаврыг фото зургаар баталгаажуулан албан бичгээр өгөх

- Хилийн шалган нэвтрүүлэх барилга, Халдваргүйтгэлийн барилгын агааржуулалтын системийг цахилгаанд холбох

- Нэг цэгийн шалган нэвтрүүлэх барилгыг бүрэн ашиглалтад оруулах

- Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгслийг бүлэн ашиглалтанд шалгаж, протокол оруулах. БНБД 21-04-05

- Цахилгаан, холбоо дохиолол, усан хангамжийн өрөөнд хаяг тайлбар бичих
Өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хийж шалгуулсан тохиолдолд комисст хүлээн авна.

Зүгшрүүлэлт хийж, проткол хөтөлж баримтжуулан, Замын-Үүд сумын ОБХ-ийн байцаагчээр хянуулж, албан бичгээр хариуг ирүүлсний дараа ашиглалтад хүлээн авна.

Ажлын хэсэг №5

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн барилгын инженер Г.Амарболд:

ЕТ №1

- 2 давхар шатны бариул шилэн хаалт хийх
- 2 давхарын гал тогооны агаар сорогч дээшлүүлэх
- Шугам сүлжээний бохир ус хаалт хийх (шугам далдлах)
- Улаан бүсийн гарах хаалганы пандусны шал (арзгар чулуу) хийгдээгүй
- Сервер тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар монгол тайлбартай болгох
- Хулдаасан шалны тэгшилгээ хийх (2-р давхрын өрөөнүүд)
- Шатны хонгил ханын хялгасан хагарал засах
- Зорчигч тээвэр хэсгийн зам талбайн ажлын их цэвэрлэгээ хийх шаардлагатай

ЕТ №9

- 2-р өрөөний агуулахын цан цохисон хэсэг ар талаараа цуурал үүссэн засварлах
- Гал унтраагчны араар орсон гэрэлтүүлгийг шилжүүлэх.
- Гадна пандусны ирмэг засах плита унасан.
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын зааврыг монгол тайлбартай болгох.

ЕТ №6/26

- Дээврийн гоёлын сайдинг битүүлэх.
- Тус барилгын дээвэр нь ашиглалттай тул хар цаас хамгаалах явган хүний зам хийх.
- Дээврийн газардуулгын хүрээ төмөр малгайг бэхлэх.
- Тоног төхөөрөмжийн ашиглалтыг монгол тайлбартай болгох.

ЕТ №15/25

- Угсралт болон тээвэрлэлтийн явцад гарсан эвдрэлийг засах.
- Халаалт болон сүлжээ монтажны ажлыг гүйцээж хийх.
- Тавцангийн хажуу хормойг дахин засварлах.
- Тоног төхөөрөмжийн ашиглалтыг монгол тайлбартай болгох.

ЕТ №14 Хил хяналтын байгууллагуудын 1 цэгийн үйлчилгээний барилга

- Гадна хаалганы онгойлт засах.
- Дотор өрөөний олон нийттэй харицах поорчик засах.
- Тоног төхөөрөмжний ашигалтыг монгол тайлбартай болгох.

ЕТ №16

- Дотор заслын ажил гүйцээж хийх
- Заставын барилгын консолдож гарсан хэсгийг дулаалах.
- Ариун цэврийн өрөөний шалыг трапруу уналттай хийх.
- Кондишнтай өрөө тасалгаанд тааз хийх.
- Өрөө тасалгаанд гарсан босоо шугамыг далдлах.
- Гал тогооны өрөөний уур сорогч хоолойн доторх конус хэлбэрийн буюу конус хэлбэртэй болгох.
- Дээврийн шахтанд босоо тор хийх.
- Дотор тоног төхөөрөмжийн ашиглалтыг монгол тайлбартай болгох.
- Дулааны оролтын худаг болон прямок дотор ханыг шавардах.
- Гадна хаалганы онгойлтыг гадагшаа онгойлттой болгох.

ЕТ №17

- Гадна усны хаялгыг засах.
- Хурд сааруулагчийг намсгах.
- Гадна хаалганы хэсгийн зам талбайг засаж борооны ус цуглуулахгүй болгох.
- Дотор тоног төхөөрөмжийн ашиглалтыг монгол тайлбартай болгох
- Цонх гүйцээж хийх. (Дутуу)
- Гадна гэрэлтүүлгийн цамхаг
- Дээш авирах хамгаалалтын шат дутуу хийгдсэн гүйцээж хийх шаардлагатай.

ЕТ №34 Монгол Улсын Хилийн багана

- Баганын дээр тавигдаж буй соёмбын нар зураг төслийн дагуу хийгдээгүй
- Багана тойрсон талбайн ажил гүйцээж хийх.

“Очиртааб” ХХК-ийн захирал Б.Чанцалмаа:

Зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх барилга болон авто зам, талбай, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын хэсэгт зохиогчийн хяналтыг графикийн дагуу цаг тухай бүрд нь үзэж ажлын журнал дээр бичиж тэмдэглэн шалгаж байсан бөгөөд зураг төслийн хэсэг бүр нь өөрсдийн холбогдох хэсгийн тус бүрээр нь саналын хуудсанд бичсэн болно. Барилгыг хийж гүйцэтгэсэн “Жунмэй инженеринг групп” ХХК нь ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэсэн гэж үзэж байнгын ашиглалтад авах саналтай байна. Ажил үүргийн биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

“Очиртааб” ХХК-ийн архитектор Д.Тамир, Д.Энхбулган, Б.Уранчимэг:

Хилийн боомтын зорчигч тээврийн хэсгийн барилга байгууламжуудын барилга архитектурын хэсгийн зохиогчийн хяналтыг графикт хугацаанд ирж тогтмол үзэж шалган ажлын журнал дээр тэмдэглэн засах зүйлүүдийн биелэлтийг тухай бүрт нь шалгаж зарим өөрчлөлтийн зургийн жижиг засваруудыг хамтран тохиролцон ажиллалаа. Гүйцэтгэгч “Жунмэй инженеринг групп” ХХК-нь ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэсэн тул зохиогчийн зүгээс татгалзах зүйлгүй. Ажил үүргийн биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Очиртааб” ХХК-ийн Барилга бүтээцийн инженер Б.Одхүү

Барилгуудын барилга бүтээцийн угсралтын хэсэгт зохиогчийн хяналтын графикийн дагуу цаг тухайд хийж ажлын журнал дээр бичиж тэмдэглэн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж байсан. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Норм, нормативийн хэлтсийн дарга Д.Алтанхуяг

- Дүүргэгч ханын суулт, хялгасан хагарал гарсан хэсэгт дахин тортой шавардлага хийх
- Галын босоо шугамнаас бусад ил байгаа шугамуудыг хайрцаглах
- 2022 оны 12-р сард ажилласан техникийн комиссын үүрэг даалгаврыг биелүүлэх
- Нээлт хийхээс өмнө 2-р давхрын шилэн хаалтыг хийж зорчигчдын аюулгүй байдлыг хангуулах
- Зураг төсөлд тусгагдсан ногоон зүлэг зэрэг ажлуудыг хийж дуусгах
- Тоног төхөөрөмжийн ашиглалтын заавруудыг орчуулах
- Инженерийн шугам сүлжээг ажиллуулж шалгаж үзэх хэрэгтэй байна. /цэвэр, бохир, шалны халаалт, агааржуулалт гэх мэт. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер Ш.Эрдэнэчимэг

ET1- Зорчигч шалган нэвтрүүлэх барилга:

- Шатны бариул хөдөлгөөнгүй болгох
- Ариун цэврийн өрөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариулуудыг хөдөлгөөнгүй бэхлэх
- Хананд гарсан цууралтуудыг засварлах
- 2-р давхрын нийтийн талбайн хашлагын шилэн хавтанг гүйцэх
- Нийтийн талбай болон албан хаагчдын өрөөний хиймэл чулуу, PVC хавтанг тэгш хэмтэй болгож засварлах
- Нийтийн талбайн хиймэл зүлэгжүүлэлтийг хийх
- Гадна хананд гарсан нүх сүвийг маш сайн хөөсөнцөр шахаж битүүлэх
- Барилгын цэвэрлэгээг маш сайн хийх
- Албан хаагчдын өрөөний босоо шугамуудыг далдалж хаалт хийх

ET17-Халдваргүйтгэлийн барилга:

- Гадна ханын цууралтыг засварлах
- Замын ус зайлуулах трапыг ажиллагаатай болгох
- Барилгын цэвэрлэгээ хийх

ET16-Хилийн заставын барилга:

- 2-р давхрын өрөөнүүдийн шалны хавтанг гүйцээж хийх
- Консолын доод талын хэсгийг дулаалга хийх
- Дотор заслын ажлыг гүйцээж хийх
- Бохирын босоо шугамыг ханаруу шахаж өгөх, далдалж хаалт хийх
- Эйр кондейшн, гэрлийн абжурыг зохистой байрлуулах

ET6, ET26-Нэг цэгийн шалган нэвтрүүлэх барилга:

- 1, 2-р давхрын саравчны металл хавтангийн дээд талыг металл хавтангаар битүүмжлэх
- Гипсэн таазыг зургийн дагуу хийх
- Гадна шатны хашлагад хаалга хийх
- Дээвэр дээр явган хүн явахад зориулж хар цаасыг хамгаалж тусгай материалаар зам хийх
- Салхивчны янданг өндөрлөх /200мм/

ET15, ET25 Шалгаагчийн кабин:

- Суурийн заслын хөндийрсөн хэсгийг дахиж хийх
- Кабины дотор цахигаан дулааны ажлыг гүйцээж хийх
- Хагарсан цонхыг солих

ET13, ET23-Авто пүү, пүүний үдирдлагын байр /суурь/:

- Пүүг суурилуулах, хэмжилтийг баталгаажуулах

ET5-Эрэлч нохойн өвлийн сургалтын байрны барилга:

- Гадна ханын засал дахин хийх

ET9-Гаалийн газрын агуулахын барилга:

- Гадна довжооны хиймэл чулуун хавтанг гүйцээж хийх
- Суурь ханын уулзвар хэсгийн дулаалга битүүмжлэлийг гүйцээх
- Дотор гадна заслыг гүйцээх
- Салхивчны яндангийн малгайны бэхэлгээг сайжруулах, солих
- Хаявчны бетон цутгалтын ажлыг гүйцээх

ET35-Дулаан хуваарилах төвийн барилга:

- Гадна, дотор заслын ажлыг гүйцээх

ЕТ37-1, ЕТ37-2 Хаалттай дэд өртөөний барилга /ХТП/:

- Шалны будаг хийх
- Хаявчны хагарал засварлах
- Гадна, Дотор заслын ажлыг гүйцээх. Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газрын захирагчийн ажлын албаны Ерөнхий архитектор Б.Цогтбаяр:

- Цогцолборын барилгын орох гарах хаалганд хязгаарлагч буюу тайвшруулах нугас хийх.
 - 2-р давхрын хязгаарлагчийн никель бариулыг гүйцээх
 - Тойрсон хэсгийн хатжуулсан шилийг хийж гүйцэтгэх
 - Суудлын автомашины халдваргүйтгэлийн барилгын тоног төхөөрөмж угсрах
 - Гарах хэсгийн постны ил шугам хоолойг далдлах
 - Ариутгалын байгууламжийн гадна ус цуглуулах трапны өндөржилтийг намсгах
 - Шалгагч кабины холбоо болон цахилааны утсыг холбож хэвийн үйл ажиллагаанд оруулах
 - Шалгагч кабин №15 шил хагарсан /2ш/, хаалга доод хэсэг /1ш/ эвдрэл гарсаныг солих
 - Орох, гарах талын хаалга хийж гүйцэтгэх
 - Хилийн шалган нэвтрүүлэх заставын барилга зарим өрөөний шал хийгдээгүй байгааг хийж гүйцэтгэх, тусгаарлах шилэн ханын шил дутуу хэсгийг хийж гүйцэтгэх, барилга байгууламжийн халаалт, цэвэр усыг өгөх
 - Цогцолборын барилга байгууламж болон гадна саравчинд ус цуглуулагч, ус зайлуулагч хоолойг хийж гүйцэтгэх
 - Зарим хэсгийн хананд хялгасан цууралт үүссэнийг засварлах
 - Орох, гарах хэсгийн тусгаарлах ханын шалыг зургийн дагуу хийж гүйцэтгэх /№1/
 - Нэг цэгийн шалган нэвтрүүлэх барилгын харуулын цэгрүү хөндий шал хийх
 - УДДТ хэрэглээний халуун усны ялтсан бойлуурын ачаалал хүрч байгаа эсэх
 - Бичиг баримтын бүрдлийг хангаж архивт хүлээлгэж өгөх
 - Заставын барилгаын 3-р давхрын консолын хэсгийн дулаалга хийх
 - Гадна зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээ хийж гүйцэтгэх, зориулалтын хогийн цэгт зөөвөрлөх
 - Хот байгууллалтын мэдээллийн санд гүйцэтгэлийн зургийг оруулах
- Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо” ТББ-ын Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн Ц.Цэрэнням:

- Ариун цэврийн өрөөнд байх хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай тоноглол бүрэн сайн хийгдсэн
 - Хараагүй хүний хөтөч зам дээр чиглэл өөрчлөх хавтанг солих
 - Авто зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай зогсоол гаргаж тэмдэг тавих
 - Хараагүй хүний хөтөч замыг байгууламжийн дотор гүйцээж хийх
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй,халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Л.Бямбатуяа:

- Агаар сэлгэлийн систем, цэвэр бохир усны ажиллагааг ашиглагчтай хамтран үзлэг хийж баримтжуулах
 - Суудлын машины халдваргүйтгэлийн төхөөрөмжийг холбож хэвийн ажиллагаанд оруулах
 - Гадна хог хаягдлыг цэвэрлэх
 - Зорчигч нэвтрүүлэх хэсгийн ариун цэврийн өрөөний хөгжлийн бэрхшээлтэй иргэн зориулсан угаалтуурын тоноглолыг хөдөлгөөнгүй бэхлэх
 - Шалгагчийн кабины хөргөлтийн төхөөрөмж, цахилгаан конвектор, гадна дотор цахилгаан холбож ажиллах нөхцлийг хангах
 - Зорчигчийг шалган нэвтрүүлэх төв барилгын гал тогооны угаалтуурын сифоныг битүүлээлийг сайжруулах
 - Халаах хэрэгслийн дамнуруу тойрсон шугамыг битүүмжилж хамгаалах хаалт хийх
 - Өрөөнүүдэд ил байрласан кондейшны уур гаргах хоолой, борооны ус гадагшлуулах хоолойнд хаалт хийж далдлах
- Дээрх ажлын гүйцэтгэлээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Комиссын дарга Ц.Баярмаа:

Зорчигч шалган нэвтрүүлэх барилга:

- 2-р давхрын нийтийн талбайд хашлага хийц, шилэн хаалтны дутуу хэсгийг гүйцээх
- 1-р давхрын нийтийн талбайд хиймэл зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцээх
- АЦӨ-ний тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан тоноглолыг хөдөлгөөнгүй болгож бэхлэх
- Нийтийн талбай болон зарим өрөөнүүдэд шалны ажллуудыг засварлах /хиймэл чулуу, PVC хулдаас/
- Нийтийн талбай олон албан өрөөнүүдэд ил угсарсан шугамуудыг далдлах
- Хананд үүссэн хялгасан хагарлыг засварлах
- Дээврийн хог шороог цэвэрлэх
- Салхивчны шахтны дээр тавьсан торон хаалтыг өөрчилж босоо тор хийх

Халдваргүйтгэлийн барилга:

- Тоног төхөөрөмжийг бүрэн угсарч хэвийн ажиллагаанд оруулах
- Ус зайлуулах трапыг ажиллагаатай болгох

Хилийн шалган нэвтрүүлэх заставын барилга:

- Дотор засал, шалны ажлуудыг гүйцээх
- Консоль хэсгийн дулаалга хийх
- Ил гарсан босоо шугамыг далдалсан хаалт хийх

Нэг цэгийн шалган нэвтрүүлэх байрны барилга:

- Саравчны гоёлын металл хавтангийн дээд хэсгийг битүүлэх
- Дээврийн хэсэг байнгын ашиглалттай байх тул хар цаасыг гэмтэхээс хамгаалсан арга хэмжээ авах

- Гадна шатны хашлагад хаалга хийх

Шалгагчийн кабин /орох, гарах/:

- Хагарсан цонх 2ш, гэмтсэн хаалга 1ш шинээр солих
- Дотор цахилгаан, халаалт, дотоод сүлжээний ажлыг гүйцээх
- Бүх барилгуудад халаалтыг жигдрүүлж, цэвэр усыг өгч, тоноглолыг ажиллагаанд оруулах
- Салхивчийн тоноглол, камержуулалт, дотоод сүлжээнд туршилт тохируулга хийж хэвийн ажиллагаанд оруулах

Дорноговь аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга бөгөөд Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч Ч.Чулуунцэцэг:

“Хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийн хүрээнд хийгдсэн Замын-Үүд боомтын цогцолборын барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгүүдийг нэг бүрчлэн хянаж үзэхэд дараах саналыг гаргаж байна.

- Зарим барилгын ил далд ажлын акт дутуу бичигдсэн, гарын үсэг зураагүй байгааг бүрдүүлэх.
- Барилга байгууламжийн угсралтын ил далд ажлын үе шатны гэрэл зургийг бүрдүүлэх
 - Актуудад техникийн алдаанууд байгааг бүрэн засварлах.
 - Барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгүүдийг эх хувиар бүрдүүлж төрийн архивт хүлээлгэн өгөх.
 - Зураг төслийн баримт бичгүүдийг батлагдсан журмын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэх.
 - “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгж, Барилгын хөгжлийн төв, гүйцэтгэгчийн хамтарсан ажлын хэсэг томилж төрийн архивт баримт бичгийг хүлээлцэх
 - -Ил далд ажлын гэрэл зургийг DVD-д хуулж өгөх.
 - Техникийн болон улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж гэрэл зургаар баталгаажуулах.
 - Гүйцэтгэлийн болон өөрчлөлтийн зураг гаргаж баталгаажуулах.

Төрийн архивт хүлээн авах баримт бичгүүд:

- 22 объектын ажлын зураг
- Гэрэл зураг
- Ашигласан баримтын гарал үүслийн гэрчилгээ /баталгаат орчуулгатай/
- Ажлын төсөв
- Хувийн хэрэг
- Талбайн журнал
- ТЭЗҮ
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
- Гүйцэтгэлийн зураг
- Өөрчлөлтийн зураг
- Загвар зураг
- Инженер геологийн судалгааны дүгнэлт гэх мэт.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Дорноговь аймаг дахь Хилийн боомтын захиргааны дарга О.Баярсайхан:

Замын-Үүд хилийн боомтын өргөтгөл шинэчлэлтийн ажилтай танилцлаа. Сайхан бүтээн байгуулалт болсон байна. Комисст ажилласан мэргэжлийн хүмүүсийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр барилга байгууламжийг ашиглалтад авах татгалзах зүйлгүй.

Хилийн цэргийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа В.Намхайнямбуу:

Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн хэсгийн өргөтгөл шинэчлэлтийн ажил үндсэндээ дуусч 2023.01.08-наас БНХАУ-ын талаас олон улсын хилээ нээж байгаатай холбогдуулан Замын-Үүд боомтын үйл ажиллагаа сэргэж, бид шинэ цогцолбороороо дамжуулан зорчигчдыг нэвтрүүлэх бэлтгэл ажилдаа ороод байна. Хилийн заставын барилга дээр улсын комиссын гишүүдтэй манай холбогдох ажилтнууд хамтарч үзэж танилцан дараах дутуу ажлуудыг гүйцэтгэх үүрэг даалгавар өгч байна. Үүнд:

Хилийн заставын барилга:

- 2-р давхрын өрөөнүүдийг хулдааслах
- Заставын барилгын дулааныг холбуулах
- Цахилгааны холболтуудыг гүйцэд хийж дуусгах

- Өрөө тасалгаануудын дутуу гэрлүүдийг суурилуулах
- Усанд орох өрөөний шилэн хаалтыг угсрах
- Агааржуулалт салхивчийг ажиллагаанд оруулах
- Хөргөлтийн системийг ажиллагаанд оруулах
- 2-р давхрын кондейшнтэй өрөөнд дүүжин тааз хийж битүүлэх
- Хоолны заалны тусгаарлах шилэн хаалтыг хийж битүүлэх
- 3-р давхрын цонхыг шиллэх
- Сервер, узель, цахилгааны шитний зааварчилгааг Монгол хэл дээр болгох
- Гал тогооны цонх хөлөрч байгааг солих

Нийт барилга байгууламж, зам талбай:

- Барилга байгууламж, зам талбайн орчны хог хаягдлын яаралтай цэвэрлэх
- Шалгагчийн кабинудын цахилгаан, халаалт, сүлжээний асуудлыг шийдвэрлэх
- Цогцолборын хашааны ажлыг яаралтай дуусгах

Улсын комисст ажилласан мэргэжлийн байгууллагууд, гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх Гаалийн газрын дарга О.Цэенрэгэн:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажил дуусч 2023.01.08-наас зорчигчдыг шинэ цогцолбороороо дамжуулан нэвтрүүлэх бэлтгэл ажилдаа ороод байна.

Зорчигч тээврийн хэсгийг үйл ажиллагаанд орохоос өмнө нэн яаралтай дараах ажлуудыг гүйцэтгэх хэрэгтэй байна. Үүнд:

- Боомтын гадна хашаа болон орох гарах хаалга бүрэн ашиглалтад оруулах
- Цогцолборын 1-р давхрын шилэн хаалтны шалны чулуун зурвасыг дуусгах
- 2-р давхрын хязгаарлагч шилийг гүйцээх, хашлага гүйцээх
- Шилэн фасад, цонхны шилний цэвэрлэгээг яаралтай хийж гүйцэтгэх
- Бүх хятад ханз бичгийг Монгол тайлбартай болгох /Холбоо дохиолол, агааржуулалт ус, дулаан гэх мэт.

Барилга ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг биелэлтээр ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Комиссын дарга Ц.Баярмаа:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.1-д “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ” гэж заасан. Замын-Үүд боомт 2023.01.08-ны өдрөөс зорчигчдыг шинээр баригдсан шалган нэвтрүүлэх барилгаараа дамжуулан нэвтрүүлэхээр хил, гаалийн байгууллагууд бэлтгэл ажилдаа орж байгаатай холбогдуулан уг барилгад дутуу хийгдсэн ажлуудыг нэн яаралтай дуусгах.

Барилгын тухай хуулийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-т “14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заасан байдаг. Хуулинд заасан хугацаагаар гүйцэтгэгч талаас баталгаа гаргуулж авна.

“Жунмэй инженеринг групп” ХХК-ийн төслийн зөвлөх Ү.Мөнхтөгс:

Боомтын шинэчлэлтийн ажилд гүйцэтгэгч талаас 1 жилийн чанарын баталгаа гаргаж өгөхөөр ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсан. Манай талаас нэг жилийн хугацаанд барилга байгууламжийг ашиглалтад зүгшүүлж, гарсан зөрчлийг бүрэн арилгаж ажиллана.

“Ай Пи Пи Ар интернэйшнл Инженеринг” ХХК-ийн хяналтын инженер Ми Шиан Чан:

Барилга ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, хурлын тэмдэглэлийг холбогдох газруудад нь хүргүүлж, хариуг та бүхэнд хүргүүлнэ.

Комиссын дарга Ц.Баярмаа:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдсан Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн хэсгийн барилга байгууламж, авто зам талбай, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комисс 2023.01.02-03-ны өдрүүдэд ажиллаж комиссын гишүүд өөрсдийн хариуцсан салбар, мэргэжлийн чиглэлээр үүрэг даалгавар, санал дүгнэлтээ танилцуулж комиссын хурал өндөрлөж байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж 2023.01.08-ны өдрөөс Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн хэсэгт хил, гаалийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж эхлэх гэж байна. Иймд зорчигчдын аюулгүй байдлыг хангах тал дээр захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагууд онцгойлон анхаарч, нэн шаардлагатай ажлуудыг яаралтай дуусгах.

Боомтын өргөтгөл, шинэчлэлтийн ажил нь Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу хийгдэж байгаа томоохон бүтээн байгуулалтын ажил учраас барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг захиалагч, гүйцэтгэгч талуудаас ханган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Замын-Үүд боомтын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн БНХАУ-ын “Жунмэй инженеринг групп” ХХК-д комиссын нийт бүрэлдэхүүний өмнөөс талархал илэрхийлье.


Шийдвэрлэсэн нь: Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврыг ажлын 14 хоногт багтаан бүрэн биелүүлж, үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлсний дараа байнгын ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 2023.01.03-ны өдрийн 15 цаг 30 минутанд өндөрлөв.

Саналын хуудсыг хавсаргав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

КОМИССЫН ДАРГА:



Ц.БАЯРМАА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



А.ЕРМЕК

Ш.ЭРДЭНЭЧИМЭГ